



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/338

Мандалговь

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалт аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1.7 дахь заалт аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 13 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрөөс иргэдэд үзүүлж буй 600 гаруй төрийн үйлчилгээний төлбөр тооцоог хийх “Гэрэгэ” киоск смарт төхөөрөмж худалдан авахад 3,500.000 (Гурван сая таван зуун мянган) төгрөгийн зардал гаргасугай.

2. Зардалд шаардагдах 3,500.000 (Гурван сая таван зуун мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210961